

ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ, ЗОРИЛТОТ СЕКТОРООР
2020.4-2021.6 САР (тэрбум төг)

4,234.7



Өрхийн
хэрэглээг
дэмжих

1,029.3



Бизнесийн
орлогыг
дэмжих

571.3



Эрүүл
мэндийн
үйлчилгээ

ТӨСВИЙН ШИНЖИЛГЭЭ

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Төсвийн зөвлөлөөс эрхлэн гаргав.

2021 оны Зургаадугаар сар
Цуврал №2

КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТӨСВИЙН БОДЛОГО

АСУУДАЛ

НӨХЦӨЛ БАЙДАЛ

ШААРДЛАГАТАЙ АЛХМУУД



НИЙТИЙН ТӨСӨВ, САН ХӨМРӨГИЙГ УДИРДАХАД
ТАТВАР ТӨЛӨГЧ ИРГЭН БҮР МЭДЭЭЛЭЛТЭЙ
ОРОЛЦОЖ, ХЯНАЛТ ТАВИХ ЭРХТЭЙ.



ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ

Төрийн төсөв, санхүүд тавих хяналтыг сайжруулах, мэдээллийн урсгалыг нэмэгдүүлэх, бодлого шийдвэрт иргэдийн дуу хоолойг тусгахад дэмжлэг үзүүлэх зорилгоор “Төсвийн Зөвлөл”-ийг Нээлттэй Нийгэм Форумгаас санаачлан 2021 оны 3 дугаар сард байгуулсан юм. Төсвийн Зөвлөл нь хараат бус шинжээчдээс бүрдэж буй бөгөөд иргэд нийтийн төсөв, сан хөмрөгийг удирдахад мэдээлэлтэй оролцох, хяналт тавих боломж нөхцөлийг бүрдүүлэх үндсэн дээр нийтийн сан хөмрөгийн оновчтой зарцуулалтыг дэмжих зорилгыг дэвшүүлэн ажиллаж байна.

ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Н.Энхбаяр, Эдийн засагч

Н.Дорждарь, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэнгийн Монгол Улс дахь менежер

А.Батпүрэв, “Санхүүгийн хүртээмж-хөгжил” ТББ-ын Үүсгэн байгуулагч, гишүүн

Л.Болормаа, Санхүүч, “BFAS” санхүүгийн зөвлөх үйлчилгээний компанийн Гүйцэтгэх Захирал

С.Боргил, Санхүүч, “Сэргэлт Консалтинг Групп” компанийн захирал

Г.Бумчимэг, Банк Санхүүгийн Академийн Гүйцэтгэх захирал

Ц.Мөнхбаяр, Эдийн засагч, санхүүч, Байэр Адвайзори ХХК-ийн зөвлөх

П.Эрдэнэжаргал, Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

Д.Оюунбадам, Төсвийн зөвлөлийн нарийн бичгийн дарга, Нээлттэй Нийгэм Форумын Засаглалын хөтөлбөрийн менежер

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх “Төсвийн Зөвлөл” нь манай улсын төсөв, санхүүгийн асуудлаар тогтмол хэлэлцэж, бодлогын шинжилгээ хийн, үр дүнг энэхүү цувралаар бодлого боловсруулагчид, мэргэжилтнүүд, олон нийтэд хүргэж байна. “Төсвийн зөвлөл” хоёр дахь хэлэлцүүлгээ “Ковид-19 цар тахлын эсрэг төсвийн бодлого” сэдвээр хийлээ. Энэ удаагийн хуралдааны дүн шинжилгээг Зөвлөлийн гишүүн А.Батпүрэв нэгтгэв.

АСУУДАЛ

Ковид-19 цар тахлын улмаас үүдсэн эдийн засгийн гэнэтийн уналт нь олон орны хувьд эдийн засгийн нөхцөл байдал төдийгүй улс төр, төрийн институцийн системийг бүхэлд нь сорилтод оруулж байна. Нэн ялангуяа эдийн засгийн хөгжлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх, амьдралын чанарыг сайжруулах, нийгмийн тэгш шударга байдлыг хангах зэрэг зорилтыг хэрэгжүүлэхэд төсвийн бодлого нэн чухал ач холбогдолтой болохыг энэхүү хямрал улам бүр тодорхой болголоо.

Цар тахлын үеийн төсвийн бодлого нь дараах дөрвөн зорилгод үйлчлэх шаардлагатай.¹ Үүнд:

1. Эрүүл мэндийн хохирлын эсрэг салбарын бэлэн байдал, найдвартай ажиллагааны эдийн засгийн баталгааг хангах;
2. Хөл хорио, хязгаарлалттай холбоотойгоор иргэд, аж ахуйн нэгжийн амьжиргаа, бизнесийн үйл ажиллагаанд учирч буй сөрөг нөлөөллийг бууруулах;
3. Эдийн засгийн сэргэлтийг дэмжиж аль болох хурдтайгаар хямралаас гарах;
4. Эдийн засаг, эрүүл мэндийн системийн дархлааг сайжруулж дараа дараагийн болзошгүй шокийн эсрэг чадавх бүрдүүлэх.


¹ OECD, Tax and fiscal policy in response to the Coronavirus crisis, 2020.

2020-2021 онд дэлхийн бараг бүх улсын Засгийн газар Ковид-19 цар тахлын эсрэг төсвийн бодлогын хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхдээ бодлогын дараах арга хэрэгслүүдийг өргөнөөр ашигласан байна. Үүнд:

- Төсвийн нэмэлт зарлага (бараа, үйлчилгээ худалдан авалт);
- Засгийн газраас бэлэн мөнгө олгох;
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, хойшлуулалт;
- Нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, хойшлуулалт;
- Өр төлбөрийн хөнгөлөлт, чөлөөлөлт;
- Төсвийн зээл, батлан даалт, баталгаа;
- Бизнес төсвөөс олгох татаас.

Монгол Улсын хувьд эдгээр бодлогын хэрэгслийг бүгдийг ашигласан бөгөөд 2020 оны 4 дүгээр сараас 2021 оны 6 дугаар сарын хооронд 3.27 их наяд төгрөгийн төсвийн нэмэлт зарлага, 1.9 их наяд төгрөгийн төлөвлөсөн орлогын хөнгөлөлт, чөлөөлөлт, 649 тэрбум төгрөгийн төсвийн гадуурх санхүүжилт², нийт 5.1 их наяд төгрөгийн дүнтэй тэнцэх хариу арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. Зөвхөн төсвийн шууд зарлагын дүнгээр авч үзвэл, энэ дүн нь өнгөрсөн оны ДНБ-ий 8.8 хувьтай тэнцэж байгаа нь дэлхийн дунджаас өндөр бөгөөд өндөр хөгжилтэй орнуудын түвшинд байна (Зураг 1).

ЗУРАГ 1. КОВИД-19 ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ХЭМЖЭЭ ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ³



² Эрдэнэс Тавантолгой ХК-ийн иргэдэд олгосон ногдол ашгийг оруулаагүй.

³ IMF, Policy responses to COVID-19 Tracker, <https://www.imf.org/en/Topics/imf-and-covid19/Policy-Responses-to-COVID-19>

Энэхүү гэнэтийн их хэмжээний зарлага ба орлогын тасалдлын улмаас төсвийн алдагдал нэмэгдэж түүнийг дагаад Засгийн газрын өр өсөж буй нь дийлэнх улсын хувьд дараагийн хүндрэлийг бий болгох төлөвтэй байна⁴.

Иймд цар тахлын эсрэг төсвийн арга хэмжээ үр дүнтэй болоход ил тод байдлыг хангаж бодлогын хэлэлцүүлэг өрнүүлэх, урт хугацааны үр нөлөөг авч үздэг байх нь чухал юм.

НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хариуцлага, тайлагнал

Монгол Улсын Засгийн газар 2020 оны 4 дүгээр сард “Коронавируст цар тахлын эсрэг 5.1 их наяд төгрөгийн багц хөтөлбөр” танилцуулж 10 дугаар сард зарим арга хэмжээний хэрэгжих хугацааг сунгасан бол 2021 оны 2 дугаар сард “Эрүүл мэндээ хамгаалж эдийн засгаа сэргээх 10 их наядын цогц төлөвлөгөө” хэрэгжүүлэхээр зарласан. Мөн 2020 оны 12 дугаар сар, 2021 оны 4, 5 дугаар сард дээрх хөтөлбөр, төлөвлөгөөнд тусаагүй цахилгаан, дулаан, усны төлбөрийг төр хариуцах, иргэн бүрт 300 мянган төгрөг олгох, вакцин хийлгэсэн иргэн бүрт 50 мянган төгрөг олгох гэх мэт шийдвэрүүдийг Засгийн газар гаргасан билээ.

Эдгээр хөтөлбөр, шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тогтмол гаргаж нийтэд тайлагнах практик байхгүй байна. Сангийн яамны эх сурвалж хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргаагүй, төсвийн урсгал болон хөрөнгийн зардлын тусгай ангилал байхгүй зэрэг шалтгааны улмаас Ковид-19 цар тахалтай холбоотойгоор гарсан төсвийн зардлын

нэгдсэн дүнг одоогоор хэлэх боломжгүй гэсэн хариулт өгсөн юм.

2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр батлагдаж 2021 оны 6 дугаар сарын 30 хүртэл хэрэгжсэн тусгай хуулиар⁵ “...жилийн батлагдсан төсвийн нийт зарлагын хэмжээг нэмэгдүүлэхгүйгээр хөрөнгийн болон урсгал зардал хооронд төсвийн зохицуулалт хийх” эрхийг Засгийн газар болон аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга нарт олгосон боловч цар тахлын холбогдолтой зардлыг тусгайлан бүртгэж тайлагнах зүйл алга байна.

Ийнхүү цар тахалтай холбоотой төсвийн зарлага ил тод бус байгаагаас бодлогын зорилго, үр нөлөө гажуудах эрсдэлтэй. Хэвлэлд мэдээлснээр (албан ёсны тайлан хараахан ил болоогүй) Төрийн Аудитын байгууллагаас Монгол Улсын 2020 оны төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланд хийсэн аудитаар⁶ нийт 3.6 их наяд төгрөгийн алдаа зөрчил илрүүлсэн бол ННФ-ын мониторингийн тайланд⁷ тэвчиж болохуйц өндөр дүнтэй төсвийн зардлууд гарч байна гэжээ.

⁴ IMF, Fiscal monitor, Apr 2021.

⁵ Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль

⁶ <https://www.ulsturch.mn/article/44509>

⁷ Нээлттэй Нийгэм Форум, Монгол Улсын 2020 ба 2021 оны төсвийн зарлагын дүн шинжилгээ, 2021 оны 4 сар.

Бодлогын арга хэрэгслүүд

Сангийн яамнаас 2020 оны 11, 2021 оны 4 дүгээр саруудад цар тахлын эсрэг хөтөлбөрүүдийн явцын мэдээллийг танилцуулга хэлбэрээр гаргаж цахим хуудсандаа нийтэлжээ. Уг мэдээллийг ОУВС зэрэг бусад эх сурвалжийн мэдээлэлтэй нэгтгэх, харьцуулах байдлаар

Ковид-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн төсвийн бодлогын арга хэрэгслүүд, тэдгээрийн дүнг энэ хэсэгт тоймлов (Хүснэгт 1). Үүнд мөнгөний бодлогын хүрээнд хэрэгжүүлсэн хөнгөлөлттэй зээл, зээлийн эргэн төлөлт хойшлуулах гэх мэт арга хэмжээний дүн мэдээлэл багтаагүй болно.

ХҮСНЭГТ 1. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСВИЙН БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭ, 2020.4-2021.6 САР

Бодлогын арга хэмжээ		Дүн (тэрбум ₮)
1	Төсвийн шууд нэмэлт зарлага	3,270.6
1.1	Төсвийн тодотголоор эрүүл мэндийн салбарт нэмж хуваарилсан	157.3
1.2	Эрүүл мэндийн салбарт зээл тусламжаар хэрэгжүүлсэн	254.4
1.3	Хүүхдийн мөнгөний нэмэлт санхүүжилт	1,330.9
1.4	Ажилгүйдлийн даатгалын тэтгэмж	44.1
1.5	Хүнсний талоны нэмэлт зардал	20.0
1.6	Халамжийн тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэтгэмж	88.2
1.7	Ноолуурын татаас	174.9
1.8	Иргэн бүрт олгосон 300 мянган төгрөг	1,000.6
1.9	Вакцин хийлгэсэн хүн бүрт 50 мянган төгрөг	34.3
1.10	Ноолуур бэлтгэгч ААН-ийн зээлийн хөнгөлөлт	6.3
1.11	Вакцин худалдан авалт	159.6
2	Төсвийн төлөвлөсөн орлого чөлөөлөлт	1,914.8
2.1	ААН-ийн НДШ-ийн хөнгөлөлт	421.9
2.2	Ажилтны НДШ-ийн хөнгөлөлт	512.3
2.3	ХХОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт	748.6
2.4	ААНОТ-ын чөлөөлөлт	78.9
2.5	Хүнсний бүтээгдэхүүний импортын татвар, чөлөөлөлт	24.3
2.6	Татварын алданги, торгууль чөлөөлөлт	110.0
2.7	Түрээсийн төлбөрийн татварын хөнгөлөлт	18.8
	Нийт төсвийн зарлага болон чөлөөлсөн орлого	5,185.4
3	Төсвөөс гадуурх санхүүжилт, дэмжлэг	649.9
3.1	Эрчим хүч, хог, усны төлбөр (ЭТТ ХК-ийн ногдол ашгийг тооцоогүй)	649.9
4	БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ НИЙТ ДҮН	5,835.3

Жич: Дээрх хүснэгтэд 3 хувийн зээлийн хүүгийн зөрүүд олгосон татаас зэрэг ил болоогүй мэдээлэл ороогүй.

ГРАФИК 1. ТӨСВИЙН БОДЛОГЫН ХЭРЭГСЛҮҮДИЙН ДҮН, ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ (2020 ОНЫ ҮНЭЭР)



2020 оны 2-р улирлаас 2021 оны 2-р улирлын хооронд Ковид-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн төсвийн бодлогын арга хэмжээний нийт дүн 5.8 их наяд болж байгаа нь 2020 оны нэрлэсэн ДНБ-ий 15.6 хувьтай тэнцэж байна. Үүнийг бодлогын хэрэгслүүдээр нь салгаж авч үзэхэд, төсвийн шууд зарлага 3.3 их наяд төгрөг байгаа нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд энэ нь ДНБ-ий

8.8 хувьтай тэнцэж байна (График 1). Эдгээр дүн нь хөгжиж буй орнуудын дундажтай харьцуулахад эрс өндөр бөгөөд хөгжингүй орнуудтай харьцуулахад ч дээгүүр үзүүлэлт юм.

Зорилтот сектор

Төсвийн бодлогын арга хэмжээ нь эрүүл мэндийн салбар, өрхийн болон хувийн хэрэглээ, бизнесийн салбар гэсэн гурван секторыг дэмжихэд чиглэснээс мөнгөн дүнгээр 86 хувь нь иргэд, өрх гэрт олгосон дэмжлэг байна. Үүний талаас илүү хувийг хүүхдийн мөнгө, иргэн бүрт олгосон 300 мянган төгрөг зэрэг шууд мөнгөн тэтгэлэгт зориулсан бол үлдэх хэсэг нь татвар, нийгмийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт зэрэг шууд бус арга хэрэгсэлд зориулсан байна.

Харин бизнесийн салбарыг дэмжих бодлогод ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг хөнгөлсөн дүн ихэнх хувийг эзэлж байна. Эдгээрээс төсвийн бодлогын арга хэмжээ нь хувийн хэрэглээг дэмжих халамжид голлон чиглэсэн бөгөөд нийлүүлэлтийн тал буюу бизнесийн салбарыг дэмжих бодлого сул байжээ гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ мөнгөний бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй зээл хойшлуулалт, хөнгөлөлттэй зээл зэрэг арга хэмжээг энд авч үзээгүй болно.

ХҮСНЭГТ 2. ЦАР ТАХЛЫН ЭСРЭГ БОДЛОГЫН АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗОРИЛТОТ СЕКТОРУУД, 2020.4-2021.6 CAP

Зорилтот сектор	Дүн (тэрбум төг)	Нийт дүнд эзлэх хувь
Эрүүл мэндийн үйлчилгээ	571.3	9.8%
Өрхийн хэрэглээг дэмжих	4,234.71	72.6%
Бизнесийн орлогыг дэмжих	1,029.3	17.6%
ДҮН	5,835.26	100%


Төсвийн тэнцэл, Засгийн Газрын өр

2020 оны эцсээр Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 4.4 их наяд төгрөг буюу ДНБ-ий 12 хувьтай тэнцэх алдагдалтай гарчээ.⁸ Төсвийн алдагдалтай холбоотойгоор Засгийн газрын нийт өр 2020 оны 1-р улирлаас 2021 оны 1-р улиралд 2.8 их наяд төгрөг буюу 11 хувиар нэмэгдсэн байна. Үүний дотор Засгийн газрын гадаад өр 15 хувь (нийт 24.4 их наяд төг.) өссөн бол дотоод өр 16 хувиар буурчээ.

Сангийн яамны мэдээлснээр⁹ 2020 онд Засгийн газар Ковид-19 цар тахлын эсрэг үйл ажиллагааг санхүүжүүлэх зорилгоор 532 сая ам.долларын төсвийн дэмжлэгийн зээл, 116 сая ам.долларын төсөл хөтөлбөрийн санхүүжилтийн гэрээ байгуулснаас оны эцсийн байдлаар 88 хувийг авч ашиглажээ. Үүний зэрэгцээ тус яамны мэдээллээс

тооцож үзвэл, өнгөрсөн онд ойролцоогоор 28 сая ам.долларын буцалтгүй тусламжийг гадаад улсын засгийн газар, олон улсын байгууллагуудаас хүлээж авчээ.

ГРАФИК 2. ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР (ТЭРБУМ ТӨГ.)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Газар

ХЭРЭГЖҮҮЛЭХ АЛХМУУД

Бодлогын үр дүнг үнэлэх

Ковид-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн төсвийн бодлогын явц, үр дүнг үнэлж дүгнэсэн иж бүрэн судалгаа одоогоор хийгдээгүй байна. Ийм нөхцөлд төрийн байгууллагуудын зүгээс өнгөрсөн онд хэрэгжүүлсэн бодлогын үр нөлөөг бодитоор үнэлж, цаашид хэрэгжүүлэх бодлогыг нээлттэй хэлэлцэх санаачилга гаргах нь зүйтэй. Түүнчлэн цар тахлын үед бодлогын тэргүүлэх зорилго байх учиртай иргэдийнхээ амь нас, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа хэр үр дүнтэй явж буйг үнэлэх шаардлагатай. Үүний тулд эрүүл мэндийн салбарын үнэлгээ нэн түрүүнд шаардлагатай.

Бид энэхүү бодлогын тоймын хүрээнд дээр дурдсан судалгаагаар хариулж болох асуултуудад хариулт өгөх зорилго агуулаагүй болно.

2017 онд батлагдсан Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийн тайлан 2018 оноос хойш гараагүй (эсвэл ил болоогүй), эрүүл мэндийн салбарын ажилтнуудын ажлын ачаалал, тоног төхөөрөмж, цалин хангамж хангалтгүй байгаа тухай асуудал байнга тавигдаж буй, Ковид-19 халдварын тархалт өдрөөс өдөрт нэмэгдэж байгаа зэрэг баримтаас үзэхэд энэ чиглэлээр хэрэгжүүлж буй төсвийн зарлагад анхаарах асуудлууд багагүй байж болзошгүй.

⁸ Сангийн яам, 2021.6.18, <https://mof.gov.mn/article/entry/2021-01>

⁹ <https://mof.gov.mn/article/entry/COVID-19-2020>

Урт хугацаанд, цогцоор харах

Төсвийн хүрээнд хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээ нь зургаан сараас нэг жил хүртэл үргэлжилсэн, эсвэл нэг удаагийн шинжтэй ажлууд байна (3 хувийн зээлийн хүүгийн зөрүүг эс тооцвол). Халдвар тархалтын эрчим буураагүй, зарим хорио хязгаарлалт үргэлжилж байгаа, гадаад нөхцөл байдал тааламжгүй зэргээс үзэхэд эдийн засаг хэвийн горимдоо ороход нэлээд хугацаа шаардагдахаар байна. Мөн түүнчлэн хямралаас үүдэлтэй ядуурал, орлогын ялгаатай байдал гүнзгийрч, боловсролын чанар, хүртээмж болон санхүүгийн секторын тогтвортой байдал буурсан зэрэг үзэгдлийг хяналтдаа авч сөрөг нөлөөг бууруулах чиглэлээр илүү урт хугацааны бодлого хэрэгтэй болж байна.

Нөгөө талаас, өнөөг хүртэл хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ нь улсын болон засгийн газрын өрийг огцом нэмэгдүүлж төсөв, эдийн засгийн бодлогод ойрын ирээдүйд ихээхэн дарамт учруулахаар байна. Иймд бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын өмнө тавигдаж буй гол сорилт нь хямралын эсрэг арга хэмжээгээ илүү урт хугацаанд өргөнөөр харж хэрэгжүүлэх, өрийн дарамтаа удирдах хоёрын оновчтой тэнцвэрийг хангах юм.

Хямралаас өсөлтөд чиглэх

Хөл хорионоос үүдэлтэй эрэлт, нийлүүлэлтийн шок явагдаж өнгөрлөө гэж үзвэл, төсвийн бодлогод өнөөг хүртэл давамгайлж ирсэн өрхийн хэрэглээнд дэмжлэг үзүүлэх чиглэлээс өсөлтийг дэмжих чиглэлд шилжих шаардлагатай. Гэвч энэ нь уламжлалт төсөв

тэлэх бодлогыг үргэлжлүүлэх төдийгөөр хэрэгжихгүй. Учир нь, Ковид-19-тэй зэрэгцэн улс орнуудын эдийн засагт бүтцийн өөрчлөлт гарч бизнес загвар, стратегийн шилжилт явагдаж эхэлсэн. Иймд сангийн бодлогоор эдийн засгийн шилжилтийг чиглүүлж шинээр тодорч буй салбаруудад нөөцийг дахин хуваарилах хөшүүрэг бий болгох зорилт тулгарч байна.

Тайлагнал, ил тод байдлыг сайжруулах

Олон улсын цар тахлын эсрэг үйл ажиллагаанд “шаардлагатай бүхнийг шуурхай хий, гэхдээ баримтаа хадгал” гэх хандлага түгээмэл харагдаж буй. Төсвийн удирдлага, хяналт, засаглалын чадавх сайтай улсуудын хувьд энэ байдал төдийлөн асуудал болохгүй байгаа бол засаглалын үзүүлэлт хангалтгүй улс орнуудын төсвийн сахилга бат, хариуцлага, хяналтыг улам бүр дордуулах нэг шалтгаан болж байгаа юм.

Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулиар Засгийн газар, орон нутгийн удирдлагуудад батлагдсан төсвийнхөө хүрээнд шуурхай зохицуулалт хийх боломж олгосон нь дур зоргоор шийдвэр гаргаж нийтэд ил тод бус байдлаар ажиллах явдлыг хамгаалах шалтаг болж байна гэж үзэж болно. Иймд уг хуульд ил тод байдал, хариуцлага, хяналтын зарчмуудыг тодорхой суулгаж өгөх нь зүйтэй. Мөн Ковид-19-тэй холбоотой урсгал болон хөрөнгийн зардлыг бүх шатанд ойлгомжтой бүртгэж, хянах аргачлалыг төсвийн журамд оруулах, “шилэн данс”-аар ил болгохыг санал болгож байна.



А.Батпүрэв нь “Санхүүгийн хүртээмж-хөгжил” ТББ-ын тэргүүнээр 2021 оноос ажиллаж байна. Тэрбээр эдийн засаг, бизнесийн удирдлагын мэргэжилтэй, хэд хэдэн салбарт стратегийн удирдлага, санхүүгийн менежмент, маркетинг зэрэг чиглэлээр мэргэшиж ажилласан.